

Төсөл  
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр сайд,  
Сангийн сайдын 2018 оны ... дугаар сарын  
...-ны өдрийн ..... дугаар тушаалын хавсралт

## **“УРГАМАЛ ХАМГААЛЛЫН АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ, САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ” ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

“Ургамал хамгааллын тухай” хуулийн /цаашид “хууль” гэх/ 8.1.8 дахь заалтыг үндэслэн уг журмыг боловсруулав.

Энэхүү журмыг Хүнс, хөдөө аж ахуй болон Сангийн асуудал Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаалаар батлуулж, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж, дугаар авсан өдрөөс эхлэн мөрдөнө.

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол орны хэмжээнд тариалангийн болон бэлчээрийн талбайд тархсан ургамлын өвчин, хөнөөлт шавж, хог ургамал, мэрэгч амьтан, дугараг хорхой /цаашид “хөнөөлт организм” гэх/ зэрэг бэлчээрийн ургамлын болон тариалангийн талбайн ургацын чанар, тоо хэмжээнд сөргөөр нөлөөлж, улс орны эдийн засагт хохирол учруулж болох хөнөөлт организмтой холбогдон авч хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

### **Хоёр. Ургамал хамгааллын арга хэмжээ**

2.1 Хуулийн 4 дүгээр зүйл болон 8 дугаар зүйлийн 8.1.9, 8.1.10 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.1- 11.1.4 дэх хэсгүүдэд заасан үйл ажиллагаанаас гадна дор дурьдсан ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Тариалангийн болон бэлчээрийн хөнөөлт организмын зүйлийн бүрэлдэхүүн, тархалт, хөнөөлийн нарийвчилсан судалгаа
- Ургамал хамгааллын цогц арга хэмжээ
- Хөдөө аж ахуйн зохистой дадал/Ургамал хамгааллын зохистой дадал
- Ургамал хамгааллын бодисын менежмент, зохистой хэрэглээ
- Ургамал хамгааллын арга хэмжээнд ашиглаж буй ургамал хамгааллын бодис, химийн бордоо болон биологийн гаралтай бэлдмэлийн зохистой хэрэглээ, аюулгүй ажиллагааны сургалт семинар, талбайн өдөрлөг /хэрэглэгч, импортлогч, аймаг, орон нутгийн хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдэд зориулсан/
- Пестицид, биологийн бэлдмэлийн хэрэглээний болон үр дүнгийн талаарх судалгаа, мониторинг
- Шинэ төрлийн пестицид, биологийн бэлдмэл турших, хэрэглэх зөвлөмж боловсруулах

### **Гурав. Ургамал хамгааллын арга хэмжээний санхүүжүүлэлт**

3.1 Ургамлын хамгааллын арга хэмжээг санхүүжүүлэх асуудлыг бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам/ болон сангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /Сангийн яам/ хамтран хариуцна.

3.2 Бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуулийн 5.4, 11.1.1-г заасны дагуу мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаас ирүүлсэн төлөвлөгөө, саналыг үндэслэн тухайн жилийн ажилд шаардагдах зардал, төсвийн төслийг жил бүрийн 3 дугаар улиралд багтаан боловсруулж батлуулна.

3.3 Санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь батлагдсан төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний зардлыг дараа оны төсөвт суулган батлуулж, батлагдсан төсвийн дагуу санхүүжилтийг олгоно.

### **Дөрөв. Ургамал хамгааллын арга хэмжээний төлөвлөлт**

4.1 Бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх хэсэгт заасны дагуу мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөнө.

4.2 Эрдэм шинжилгээний байгууллага нь ургамал хамгааллын арга хэмжээний төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, төсвийн төслийг боловсруулж бэлчээрийн

болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 12-р сарын 15-ны дотор хүргүүлнэ.

4.3 Ургамал хамгааллын арга хэмжээний төлөвлөгөөг арга хэмжээний онцлогоос шалтгаалан жил бүр эсвэл богино болон урт хугацаатайгаар боловсруулж батлуулна.

4.4 Ургамал хамгааллын арга хэмжээний төлөвлөгөөг бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

### **Тав. Ургамал хамгааллын арга хэмжээний хэрэгжилт**

5.1 Ургамал хамгааллын арга хэмжээг Эрх бүхий төрийн захиргаанаас баталсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

5.2 Ургамал хамгааллын арга хэмжээг холбогдох нийслэл, аймаг орон нутгийн төрийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

5.3 Хөнөөлт организмын тархалт, хөнөөлийн судалгаа зэрэг мэргэжлийн ур чадвар, арга зүй шаардсан ургамал хамгааллын арга хэмжээг хуульд заасан эрдэм шинжилгээний байгууллага хэрэгжүүлнэ.

5.4 Ургамал хамгааллын арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, дотоодын болон олон улсын стандарт, шаардлага ханган хэрэгжүүлнэ.

#### **5.2 Хөнөөлт организмын талаарх судалгааны ажлыг зохион байгуулах**

5.2.1 Тариалангийн талбайн ургамлын өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамлын тархалт, хөнөөлийн хэмжээг тогтоох судалгааг хуулийн 8.1.10-т заасны дагуу 3 жил тутамд 1 удаа хийнэ.

5.2.2 Судалгааны ажлыг тухайн жилийн 3 дугаар улиралд багтаан явуулна.

5.2.3 Энэхүү судалгааг тухайн эрдэм шинжилгээний байгууллагаас батлагдсан арга зүйн дагуу хийж гүйцэтгэнэ.

5.2.4 Судалгааны ажлыг тухайн жилийн 7 дугаар сарын II дахь арав хоногоос 8 дугаар сарын II дахь арав хоног хүртэлх хугацаанд бүсчилэн явуулна.

5.2.5 Судалгааг бүх бүсүүдэд нэг арга зүйгээр, нэг хугацаанд хийж гүйцэтгэнэ.

5.2.6 Судалгааг тухайн бүсэд тариалагдаж байгаа бүх төрлийн таримал дээр хийнэ.

5.2.7 Судалгааны ажлыг ургамлын өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал судлалаар мэргэшсэн, судлаачдын баг хийж гүйцэтгэнэ.

### **Зургаа. Ургамал хамгааллын арга хэмжээний үр дүнг тайлагнах**

6.1 Судалгааны ажлын тайланг “Эрдэм шинжилгээний ажлын тайлан. Бүтэц, шаардлага” MNS 2492 : 2004 стандартын дагуу бичнэ.

6.2 Судалгааны тайланг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн 12 дугаар сарын 20-ны дотор ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

6.3 Судалгааны ажлын үр дүнгээр илэрсэн өвчин, хөнөөлт шавьж, хог ургамал, мэрэгч амьтны тархалт болон хөнөөлийн хэмжээний талаарх мэдээллийг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дэргэдэх мэдээллийн нэгдсэн санд оруулна.

6.4 Ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлсэн байгууллага нь хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг гэрээнд заасан хугацаанд багтаан бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

6.5 Бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлсэн нэгдсэн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор багтаан санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

### **Долоо. Хариуцлага**

7.1 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага ноогдуулна.